



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ
НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДАД

**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

С.Зоригийн гудамж 2, 1 дүгээр хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976) 7711 1027, Цахим шуудан: info@fchm.edu.mn

2026.08.31 № 11547
танай _____ -ны № _____ -т

Үнийн санал авах тухай

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн эм зүйн албаны эм савлагааны автомат машины уут нийлүүлэх ажилд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу үнийн санал ирүүлнэ үү.

Хавсралтад тусгасан бараа материалын худалдан авах үнийн саналыг 2026 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 14:00 цаг хүртэл хүлээн авна.

Мэйл хаяг: procurement@fchm.edu.mn

Ө.Мягмарсүрэн /ЭХААҮХТА-ны менежер/

Хаяг: УНТЭ-ийн 1 давхар 6 тоот Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж, түгээлтийн алба

Хавсралт 1 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.АНХТУЯА



142262174

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий
захирлын 2026 оны 08 дугаар сарын 31-ны
өдрийн 1154 дугаар албан бичгийн хавсралт



Барааны нэр: Эм савлагааны машины савлагааны уут / Packaging film roll

Тоо хэмжээ: 50 ролл

Зориулалт: Эмийг нэг удаагийн тунгаар автомат савлан бэлтгэх зориулалттай

№	Техникийн үзүүлэлт, шаардлага	Шаардлага
1	Тохирох төхөөрөмж	Haier Biomedical Technology үйлдвэрлэгчийн HON-FB-D480 загварын автомат эм савлагааны машинд зориулагдсан, бүрэн нийцтэй байна.
2	Бүтээгдэхүүний төрөл	Автомат эм савлагааны машинд ашиглах савлагааны уут / packaging film roll байна.
3	Нийцтэй байдал	HON-FB-D480 төхөөрөмжид нэмэлт өөрчлөлт, тохируулга хийхгүйгээр шууд суурилуулан ашиглах боломжтой байна.
4	Материал	Эм, эмийн бүтээгдэхүүнийг савлах зориулалтын, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй материалаар үйлдвэрлэсэн байна.
5	Савлагааны чанар	Автомат савлагааны явцад тасрах, урагдах, хумигдах, гацахгүй, жигд татагдаж савлагддаг байна.
6	Дулааны битүүмжлэл	Төхөөрөмжийн дулаанаар наах системтэй бүрэн нийцэж, савлагааны ирмэг жигд, бат бөх битүүмжлэгддэг байна.
7	Хэвлэлт	HON-FB-D480 төхөөрөмжийн хэвлэх системээр эмийн нэр, тун, хэрэглэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг савлагаан дээр тод, уншигдахуйц хэвлэх боломжтой байна.
8	Гадаргуу	Хэвлэлт болон дулааны битүүмжлэлд тохирсон, жигд гадаргуутай байна.
9	Роллын хэмжээ	HON-FB-D480 төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс заасан савлагааны уутны роллын хэмжээ, өргөн, зузаан, дотоод голч болон бусад хэмжээсийн шаардлагыг бүрэн хангасан байна.
10	Роллын ажиллагаа	Төхөөрөмжийн ролл тогтоогч болон уут дамжуулах механизмд бүрэн тохирч, сулрах, халтирах, гацахгүй байна.
11	Савлагаа	Ролл тус бүр үйлдвэрийн анхны савлагаатай, тээвэрлэлт болон хадгалалтын явцад бохирдох, чийг авах, гэмтэхээс хамгаалагдсан байна.
12	Чанарын шаардлага	Нийлүүлэх бүтээгдэхүүн нь шинэ, өмнө ашиглагдаагүй, үйлдвэрийн чанарын шаардлага хангасан байна.
13	Үйлдвэрлэгчийн мэдээлэл	Бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, бүтээгдэхүүний нэр/код, үйлдвэрлэсэн огноо болон шаардлагатай таних мэдээлэл савлагаан дээр тэмдэглэгдсэн байна.
14	Нийцлийг нотлох баримт	Санал болгож буй савлагааны уут нь Haier Biomedical Technology HON-FB-D480 загварын төхөөрөмжид тохирохыг нотлох үйлдвэрлэгчийн каталог, техникийн баримт бичиг, албан бичиг, бүтээгдэхүүний код бүхий мэдээлэл эсхүл түүнтэй дүйцэх нотлох баримтыг ирүүлнэ.
15	Тоо хэмжээ	50 ролл